МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн

МОНГОЛ УЛСЫН
“ЧИНГИС ХААН”
ҮНДЭСНИЙ МУЗЕЙ

ОХУ-ЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн

МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ:
ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

VI

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан

Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2023 оны 4 сарын 19-21
Монгол Улс, Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Улаанбаатар – Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Хариуцлагатай редактор: Академич С. Чулуун
Эмхтгэгч-редакторууд: Хэл бичгийн шинжлэх ухааны доктор И. В. Кульганек
Түүхийн ухааны доктор (Ph.D), проф Н. Хишигт
Хэл шинжлэлийн дэд эрдэмтэн Д. А. Носов

Монголчуудын соёлын өв: Гар бичмэл ба архивын баримтын цуглуулга-VI. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. 2023 оны 4 сарын 19-21. Монгол Улс, Улаанбаатар хот. Улаанбаатар – Санкт - Петербург, 2025. – 320 тал.

Тус эмхэтгэлийг Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, “Чингис хаан” Үндэсний музей, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн хамтран 2023 оны 4 дүгээр сарын 19-21-нд Монгол Улсын Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дахь удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдээр бүрдүүлэв.

Энэхүү хурлыг зохион байгуулах эх суурь нь архив, гар бичмэлийн сан хөмрөгт хадгалагдаж буй монгол угсаатан ард түмнүүдийн хэл, түүх, улс төр, хэл, утга зохиол, шашин соёл, угсаатны зүйд холбогдох баримт материал болно.

Эмхэтгэлд монгол судлалын түүх, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, хээрийн шинжилгээний ангиудын тухай болон Монголын уламжлалт нийгэм, орчин үеийн амьдралын олон талт асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүдийг багтаав.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2025
© Монгол Улсын “Чингис хаан” Үндэсний музей, 2025
© Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2025

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

“ЧИНГИС ХАН”
Национальный музей
Монголии

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей

КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: РУКОПИСНЫЕ И АРХИВНЫЕ СОБРАНИЯ

VI

Международная конференция
при поддержке Президента Монголии

19-21 апреля 2023 г.
Монголия. Улан-Батор

Сборник докладов

Улан-Батор — Санкт-Петербург
2025

ННА 63
ДАА 900
М-694

Ответственный редактор: Академик С. Чулуун
Редакторы-составители: доктор филол. наук И. В. Кульганек
доктор (Ph.D), проф. Н. Хишигт
кандидат филол. наук Д. А. Носов

Культурное наследие монголов: Рукописные и архивные собрания. Сборник докладов VI Международной научной конференции. 19-21 апреля 2023. Улан-Батор, Монголия. УБ. — СПб., 2025. — 320 с.

Сборник представляет собой собрание докладов VI Международной научной конференции “Культурное наследие монголов: рукописные и архивные собрания», организованной Институтом истории и этнологии МАН, Национальным музеем Монголии Чингис-хан и Институтом восточных рукописей РАН в Улан-Баторе 19-21 апреля 2023 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, политике, языку, литературе, культуре, религии и этнографии монгольских народов.

В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-533-04-5
DOI 10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Институт истории и этнологии МАН, 2025
© "Чингис-хан" Национальный музей Монголии, 2025
© Институт восточных рукописей РАН, 2025

MONGOLIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of History and
Ethnology

CHINGGIS KHAAN
NATIONAL MUSEUM
OF MONGOLIA

RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts

CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

VI

International Conference
Under the Patronage of the President of Mongolia

April 19-21, 2023.
Mongolia, Ulaanbaatar

Proceedings

Ulaanbaatar – St. Petersburg
2025

ННА 63
ДАА 900
М-694

Edited and compiled by Academician S. Chuluun
D.Sc.(Philology) I. V. Kulganek
Ph.D (History), prof N. Khishigt
Cand. Sc. (Philology) D.A. Nosov

Cultural heritage of the Mongolis: Manuscripts and archival collections-VI. Papers of the VI International Conference, April 19-21, 2023. Ulaanbaatar. Ulaanbaatar-St.Petersburg 2025, 320 pages.

This is a collection of papers, presented at the Sixth International Conference organized by the Institute of History and Ethnology of the Mongolian Academy of Sciences, National Museum of Mongolia "Chinggis Khaan" and the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences, which was held in Ulaanbaatar in April 19-21, 2023.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples.

The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-533-04-5
10.48612/IVRRAN/1u5a-r7u3-48rg

© Institute of History and Ethnology MAS, 2025
© National Museum of Mongolia "Ghinggis Khaan", 2025
© Institute of Oriental Manuscripts RAS, 2025

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ

ӨМНӨХ ҮГ 10

МЭНДЧИЛГЭЭ /ПРИВЕТСТВИЯ..... 11

Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 6 дугаар удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцогсдод ирүүлсэн илгээлт..... 12

Приветственная речь Генерального секретаря Международной ассоциации монголоведения, директора Национального музея Монголии Чингис-хан, академика С. Чулууна 14

Приветствие директора Института восточных рукописей РАН, член-корреспондента РАН И. Ф. Поповой 16

Монгол Улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн захирал, (Sc.D) Ц. Цэрэндоржийн мэндчилгээ..... 18

ИЛТГЭЛҮҮД / ДОКЛАДЫ

Г. Алтансүх
Нур ад-Дины гар бичмэл дундад зууны монгол хүний нэрийн сурвалж болох нь 22

Г. Баярмаа
Берлиний Улсын номын санд хадгалагдах Монголын бурханы шашинд холбогдох баримтын тухай..... 28

Т. Баясгалан
Арташид хан хөвгүүний туужаас сэдэвлэсэн монгол тууль 43

Л. Ганбат
“Zafarnama” Монголын түүхэнд холбогдох сурвалж болох нь..... 52

Д. Дашдулам
1932 оны зэвсэгт бослогын нэгэн удирдагч Самбуу дүвчингийн тугийн талаар нэхэн үзэх нь 58

Ц. Дэлгэрсайхан
Монгол Улсын боловсролд Оросын сургагч багш, мэргэжилтнүүдийн оруулсан хувь нэмрийг архивын баримтаар тодотгох нь (1912-1942 он)..... 76

Zsolt Szilágyi
The Hungarian press perceptions of Mongolia at the beginning of the 20th century..... 89

И. М. Захарова
Караван купца Ивана Саватеева в Китай в 1702-1704 гг.
(По материалам Государственного Эрмитажа)..... 99

И. В. Кульганек
«Речь о состоянии монгольской словесности» из собрания
Института восточных рукописей РАН 108

Лицю Лю, Р. М. Валеев, Р. З. Валеева, Ю. И. Елихина, Д. Е. Мартынов
Формирование монголоведения, буддологии и тибетологии
в Казани в XIX в.: архивные фонды и материалы государственного
архива Республики Татарстан и музеев Казани 120

М. В. Мандрик
Коллекция документов по истории Русской духовной миссии
в Пекине и Монголии в собрании Научного архива ИИМК РАН 140

Д. Наранцэцэг
Хорчинба Ишжамцын намтар “Сүсэг төгөлдөр нугуудын зүрхний
энэлгийг арилгагч” хэмээх зохиолын шинжлэл 149

Б. Нацагдорж
Монгол Гэсэрийн туужийн үйсэн дээр бичсэн нэгэн эхийн тухай 162

Д. А. Носов
Загадка тетрадей Лисовского: о составе единицы хранения
« В.И. Лисовскийн тэмдэглэлийн дэвтэрүүд» из Центрального
Национального Архива Монголии 178

G.Odbayar
A Contribution to the study of Mongol bannermen: The founding policy
of the Tibetan Qing Administration, written by Sungyun 184

Э. Пүрэвжав, М. Очирцэнд
Монгол Улс дахь нутгийн аялгуу судлалыг архивын баримтаас
тодруулах нь 197

Т. Сайнжаргал
Үндэсний Төв Архивын сан хөмрөг дэх Түшээт засаг
гүн Балдардоржийн захидлын мэдээг мөшгөх нь 213

М. В. Федорова
Вклад Я. П. Шишмарева в формирование монгольского собрания
Российского этнографического музея 221

Н. Хатанбаатар
"Богд Жибзундамбын анхан төрлийн нэр оршивой" хэмээх сурвалжийн тухай 235

Н. Хишигт
О. И. Макстенек: Монголын тухай илтгэл, мэдээллүүд (1920-1921 он) 241

С. Цолмон, Ц. Энхчимэг
Еще раз о Золотоордынских тамгах Крыма 250

Ц. Цэрэндорж
Солонгосын Чосөнъ улсын үед монгол хэлний сургалтад ашиглаж байсан ном, сурах бичгүүдийн нэрийг тодруулах нь 262

S. Chuluun, Agata Bareja-Starzyńska
On the documents of the first population and statistical census of Mongolia in the 20th century kept in the archive of prof. W.Kotwicz in Cracow, Poland 274

Ц. Энхжаргал
Таван жилийн төлөвлөгөөг сайжруулах асуудалд холбогдох баримтын тойм (Монгол Улсын Үндэсний Төв Архивын материалаар) 291

ИЛТГЭГЧДИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ 310

DOI 10.48612/IVRRAN/k1d3-fpbu-a7mk *Т. Баясгалан (Монгол Улс)*

АРТАШИД ХАН ХӨВГҮҮНИЙ ТУУЖААС СЭДЭВЛЭСЭН МОНГОЛ ТУУЛЬ

Товч агуулга: XVII зууны үед монголчууд энэтхэг, төвөдөөс орчуулсан зохиолуудаас сэдэвлэж шинэ үлгэр, тууль зохиож байжээ. Ийнхүү нэг зохиолоос сэдэвлэж тууль зохиохдоо ондоо зохиолын үйл явдлыг уламжлалт монгол туулийн өгүүлэгдэхүүний загварт оруулж, цэвэр монгол ахуйг дүрсэлсэн зохиол бүтээжээ. Жишээлбэл, Банчин Лувсан-Ишийн төвөд хэлээр зохиосон Арташид хан хөвгүүний туужийн 1981 онд хэвлэгдсэн монгол орчуулгаас сэдэвлэж, тус зохиолын дүр Амгашид (Амока) ханы гэрлэсэн тухай туулийг амаар зохиожээ. Зохиохдоо Бигармижид хааны туужид гардаг Цэцэг хатныг залж ирсэн тухай үйл явдлыг ашигласан байна. “Арташид хан, Амгашид хан”, “Амгашид, Ачит хаан хоёр” зэрэг нэртэй тус тууль анх одоогийн Монгол Улсын баруун хязгаарт зохиогдож, зүүн тийш ам дамжин дэлгэрэх явцдаа өөрчлөгдөн хувьсаж, олон хувилбартай болжээ.

Түлхүүр үг: Монгол тууль, сэдэв, Арташид, Амока, өгүүлэгдэхүүн

Bayasgalan Tudev

A MONGOL EPIC BASED ON “NOVEL OF PRINCE ARTHASIDDHI”

Abstract: Since ancient times, Mongolians have translated from Indian and Tibetan literature and written as its, as well as creating new epics and fairytales based on those texts. Chakhar gevsh Luvsanchultem (1740-1810) translated “Novel of Prince Arthasiddhi” by Banchin Luvsan-Ish (1663-1737), teacher of the 7th Dalai Lama, in the Tibetan language, into the Mongolian language in 1781 and published it. This translation has been spread widely among Mongolians in written and oral form.

The novel ends with the brothers Arthasiddhi and Amoka, the main characters of the novel, each becoming the king of each country, with one queen between them. This ending seemed strange to the Mongols, so they created a new tale about the marriage of King Amoka in the narrative style of a Mongolian epic with the theme of a traditional heroic marriage. In composing the novel, the narrative in “Bigarmijid King’s Story” about the

wooing of the Flower Queen was used. The researcher believes that the epic was first composed in the western area of present-day Mongolia and spread orally to eastern part.

Key words: *Mongol epic, theme, Arthasiddhi, Amoka, subject*

Удиртгал

Эрт цагаас монголчууд энэтхэг, төвөдөөс ном зохиол орчуулах, дуурайж зохиохоос гадна тэрхүү орчуулгын зохиолуудаас сэдэвлэж шинэ үлгэр, тууль зохиодог байжээ. Үүний жишээ нь "Арташид хан, Амагашид хан", "Амгашид хаан, Ачит хаан хоёр" гэх зэрэг нэртэй монгол тууль болно.

Арташид[1] хан хөвгүүний туужийг 7 дугаар дүрийн Далай ламын багш Банчин Лувсан-Иш (1663-1737) гэдэг хүн "Сайн оюут лам, Арташид номын хаан хоёрын онолыг өгүүлсэн цэдэг нуцын эш хэмээх оршив" хэмээх нэрээр анх төвөд хэлээр зохиожээ. Лувсан-Иш тус зохиолоо эртний Энэтхэгийн "Шидэт хүүрийн үлгэр"-ийн доторх Нарангэрэл, Сарангэрэл хоёрын үлгэрийг боловсруулж зохиосон гэж Ц. Сандаг бичжээ (МУЗТ, II. 1977: 54). Эрдэмтэн Ц. Сэцэнбат олон эх сурвалжийн хүрээнд харьцуулж судлаад Банчин-Ишийн зохиосон "Арташид хаан хөвгүүний тууж нь 21 бүлэгт төвөд Шидэт хүүрийн үлгэрийн 21 дүгээр бүлгийг өөрчлөн найруулаад бий болжээ (Сэцэнбат 2020: 85) гэж 50 шахам жилийн өмнө дэвшүүлсэн Ц. Сандагийн саналыг баталсан байна.

Энэ зохиолыг цахар гэвш Лувсанчүлтэм (1740-1810) 1781 онд монгол хэлээр орчуулж, Өвөр Монголын цахар нутагт байдаг Цагаан уулын сүмд өөрийн байгуулсан хэвлэлийн газарт хэвлэжээ. Энэ хэвлэл модон бар, гар бичмэл болон амаар өргөн дэлгэрсэн байна. Тус туужийн гар бичмэл Өвөр Монгол ба Монгол Улсын номын сан, музей, хөмрөгүүдэд нэлээд олон тоогоор хадгалагдаж байна. Цахар гэвшийн уг орчуулгыг монголчууд уншихаас гадна ам дамжуулан хэлэлцэх явцдаа тус зохиолоос сэдэвлэж шинэ тууль зохиосон баримт байна. Энэ нь монголчуудын туурвил зүйн сэтгэлгээний өвөрмөц ололт болох учиртай. Чухам ямар туулийг хэрхэн зохиов гэдгийг энэ өгүүлэлд авч үзэв.

[1] Бурхан Будда нь өмнөх төрөлдөө Арташид (Arthasiddhi) хэмээх хаан байсан тухай домогтой ба түүний түүх нь буддын шашинт ард түмнүүдийн дунд өргөн дэлгэрчээ. Арташид нь artha, siddhi хэмээх хоёр үг нийлж бүтсэн, "амжилт" гэдэг утгатай санскрит үг ажээ. Монголчууд энэ үгийг Артсэд, Артаасэд, Артшид гэх зэргээр бичиж, хүүхдэдээ эртнээс өгч ирсэн уламжлалтай. Эртний монгол язгууртнууд дотор Артсэд нэртэй хэдэн хүн бий. Энд монгол бичгийн хэлбэрийг баримтлан Арташид гэж бичлээ.

1. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн: Бичвэр судлалын арга, төрөл хуваах арга, мотив судлал, харьцуулан судлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх аргуудыг хэрэглэв. Судалгааны хэрэглэгдэхүүнээр Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөгт хадгалагдаж буй "Сайн ухаант лам, Арташид номын хаан хоёрын онолыг өгүүлсэн цэдэг нуцын эш хэмээх оршвой" нэрт модон барын судар, цахар гэвшийн орчуулгаас сэдэвлэн зохиогдсон гэж үзэж буй Ховд аймгийн Буянт сумын харьяат үлгэрч Ж.Гонгорын хэлсэн "Амгашид, Ачит хаан хоёр" үлгэр, академич Б.Ринченгийн хэвлүүлсэн "Ар Замбуулин" нэртэй үлгэр, Өвөр Монголын Шинэ барга зүүн хошууны үлгэрч Даваагийн хэлсэн нэг үлгэр, нийт гурван аман үлгэр, туулийг үндсэн эх хэрэглэгдэхүүнээр ашиглалаа. Түүнчлэн судлаачдын бичсэн Бигармижид хааны тууж ба Арташид хаан хөвгүүний туужид холбогдох аман үлгэрүүдийн агуулгын товчлолуудыг эх хэрэглэгдэхүүн болгон ашиглав.

2. Тууль зохиогдох болсон шалтгаан: Арташид хааны туужид холбогдох монгол аман үлгэр, туулиуд хоёр төрөлд хуваагдаж байна.

Нэгдүгээрт, тус туужийг амаар хэлж дамжуулсан хэсэг үлгэр байна. Энэ талаар Ц. Сэцэнбатын "Бурхан шашны судрын үлгэрийн монгол аман уламжлалын судлал" (2020) гэдэг номоос үзнэ үү. Профессор Ц. Сэцэнбат "Арташид, Амокашид" хоёрын тууж бичгээр тархахын хамт монгол аман үлгэр, тууль болж ард түмний дунд дэлгэрснийг тодруулж Хөхнуурын дээд монголчууд, Өвөр Монголын Шилийн гол, Хөлөнбуйр, Шинжааны ойрад монголчуудаас тэмдэглэж авсан үлгэр, тууль нийт арав шахам хэрэглэгдэхүүнийг агуулга, үйл явдал, хувьсал өөрчлөлтийн талаас нь судалжээ. Тэдгээр үлгэр, туулиуд нь Арташид хааны туужийн бичмэлээс цээжилж, амаар хэлсэн зүйлс байх бөгөөд нийтлэг онцлог нь уг судрын эхлэл хэсэг болон төгсгөл хэсэг дэх юуны учир энэхүү туужийг зохиосон тухай бичсэн Банчин-Ишийн үгс, уг зохиолд холбогдох түүхэн орчин байдлын хэсгийг орхиж, зөвхөн гол үлгэрийн хэсгийг үлдээж, нэлээд хялбаршуулсан, олон үйл явдлыг өөрчилсөн байдаг ажээ (Сэцэнбат 2020: 91).

Хоёрдугаарт, Арташид хааны туужаас сэдэвлэж зохиосон хэсэг үлгэр байна. Үүнд Монгол Улсын Ховд аймгийн Буянт сумын харьяат үлгэрч Ж. Гонгорын хэлсэн "Амгашид хаан, Ачит хаан хоёр", Б. Ринченгийн тэмдэглэж хэвлүүлсэн "Ар Замбуулин", Өвөр Монголын Шинэ барга зүүн хошууны Шинэбулаг сумын Даваагийн хэлсэн "Арташид хан, Амагашид хан", барга ардын үлгэр "Амгаа сайт хан, Артаа сайт хан" гэдэг үлгэрүүд болно. Эндээс үзэхэд тус үлгэр Ар, Өвөр Монгол даяар баруун монгол, халх, барга монголчуудын дунд өргөн дэлгэрчээ.

Арташид хааны тууж бол нэлээд томоохон хэмжээтэй тууж болно. Дээрх үлгэрүүд Арташид хааны туужийн чухам аль үйл явдлаас сэдэвлэсэн бэ гэвэл, нэг нэгэндээ хэмжээлшгүй их элбэрэлтэй ах дүүс Арташид, Амока хоёр хөвгүүн цөлөгдөж, зүйл бүрийн зовлон зүдгүүр амсаж явсаар ах Арташид нь Гоча хааны охин Төгсгэрэлтэй гэрлэж, Гоча хааны ширээг залгамжилдаг. Харин Амока дүү нь зохиолын төгсгөлд Бхала дива хааны ширээнд суудаг ба ах дүү хоёр хаан дундаа ганц хатантай боллоо гэдэг. Энэ тухай уг туужийн модон барын сударт:

Тэндээс хаан, түшмэд, албатын нөхөр сэлтээр эцэг эхийн суусан Өлзий давхарласан нэрт ордноо өөд болов. Амока хан хөвгүүнийг эцэг хааны ширээнээ суулгаж төр эзлүүлээд, ах дүү хоёул ялгалгүй янагш чанагш төрөө мэдэлцэх бөгөөд ***хатан ч хоёул ганцхан хатнаар болох боллоо*** *(Sayinuqaɤantu... х.59 дээд)* гэжээ.

Тодруулбал, Арташид хан, Амока хан хоёр Төгсгэрэлийг дундын хатан болголоо гэж ойлгож болох мэт. Хоёр тусдаа улсын хаад дундаа нэг хатантай болсон гэх нь төвөд үндэстний ураг хуримын зан үйлийн тусгал гэнэ (Сэцэнбат, 2020: 84). Гэтэл энэ нь монгол хүнд ойлгомжгүй болно. Хоёр тусдаа улсын хаад байтал, дундаа нэг хатантай болсон гэдэгт монголчууд ихэд гайхах нь тодорхой. Ийм уламжлал монгол төрийн түүхэнд байхгүй биз ээ. Уг туужийг унших буюу сонсоход Арташид хан Төгсгэрэл гэдэг хатантай болж, харин Амока хан хатангүй үлддэг. Тиймээс монголчууд өөрсдийн заншлаар Амока (Амгашид) ханыг хатантай болгох зорилгоор Амгашидийн гэрлэсэн буюу хатан залсан тухай туулийг амаар зохиохдоо уламжлалт баатарлаг гэрлэлтийн сэдэвт монгол туулийн өгүүлэгдэхүүний загварыг ашиглажээ. Чухамдаа эртний Энэтхэгийн Бхала дива орны хан Амокад монголчууд эхнэр авч өгчээ гэж ч болох мэт. Үлгэрийг зохиохдоо Амока гэдэг нэрийг Арташидтэй ижилсүүлж дуудлагыг монголжуулж Амгашид болгожээ. Уг хоёр нэрийн дуудлага ярианы хэлэнд сунжирч Арташид нь Артаа сайт[2], Амгашид нь Амгаа сайт, Ачит хаан болсон байна.

Хөлөнбуйрын баргуудын дунд дэлгэрсэн “Амгаа сайт хан, Артаа сайт хан” үлгэрийг профессор Ц. Сэцэнбат судлаад хэдийгээр үлгэрийн нэрийн хувьд Арташид, Амгашидийн туужийн нэртэй адилавтар боловч “Арташид, Амгаашидийн туужийн нэгэн аман хувилбар бус, харин монгол газар ам, бичгээр өргөн дэлгэрсэн Бигармижид хааны туужид

[2] Проф. Ц. Сэцэнбатын “Бурхны шашны судрын үлгэрийн монгол аман уламжлалын судлал” (УБ., 2020) номын кирилл үсгээр хэвлэгдсэн эхийг энд ашигласан болно. Цаашид судлаачид “Амгаа сайт, Артаа сайт” гэдэг нэрүүдийг ашиглахдаа тус номын монгол бичгийн хэвлэлтэй тулгаж нягтална уу.

Бигармижид хаан Цэцэг хатныг залсан тухай үлгэрийн аман хувилбар мөн” (Сэцэнбат, 2020: 104) гэжээ.

Гэтэл Бигармижид хааны тууж, Арташид хаан хөвгүүний тууж нь хоёр ондоо зохиол. Монголчууд Амока хан хөвгүүний гэрлэсэн тухай үлгэрийг зохиохдоо яагаад Бигармижид хаан Цэцэг гэдэг хүүхнийг хатан болгож авсан тухай үйл явдлыг ашиглав гэдэг нь анхаарал татаж байна. “Бигармижид хааны монгол намтарт Энэтхэгийн орны Махасамади нэрт хаанд гурван хөвгүүн байжээ. Хоёр их хөвгүүн нь эхнэртэй. Отгон хүү Бигармижид нь 12 настай бөгөөд эхнэр аваагүй байв. Бигармижид нэг өдөр ан хийж яваад цангаж ахынхаа гэрт очиж бэргэнээс унд гуйвал, бэргэн нь юм оёж байсан тул “Шивэгчинд хэлж унд уу” гэв. Бигармижид бэргэнээ “Муу сэтгэлт хүн байна” гэсэнд, бэргэн нь “Чи сайн эр бол цэцгээс мэндэлсэн сайхан эхнэрийг олж аваад ир. Би үзье” гэв. Бигармижид “Би тийм эхнэрийг олж авчиръя. Эс олбол буцаж ирэхгүй” гэж хэлээд явна. Бигармижид явсаар Вачир йогини гэдгийн сүмд хүрч, тэр йогиноор Цэцэг хүүхнийг олох аргыг заалгаж, тэр дагуу явсаар замдаа нэг шулмыг дарж, Мапам далайн хөвөөнөөс нэг цэцгийг олж авчрав. Тэр цэцгийг Вачир йогини нээж үзвэл гэрэлт Цэцэг хүүхэн гарч ирдэг” (МУЗТ, II. 1977: 298). Энэ үйл явдал нь бидний авч үзэж буй Арташид хааны туужаас сэдэвлэгдсэн гэх үлгэр, туулиудын үйл явдалтай их төстэй.

Ижил төстэй байдлыг тайлбарлахдаа монголчууд Бигармижид хааны гэрлэсэн үйл явдлыг Амока хан хөвгүүний гэрлэлт гэж андуураад зохиолын нэрийг “Арташид, Амагашид хан” гэх мэт болгосон гэж шууд хэлж арай боломгүй санагдана. Харин монголчууд уран сайхны чухал боловсруулалт хийж, Амока хан хөвгүүний гэрлэсэн тухай үлгэрийг зохиохдоо Бигармижид хаан хөвгүүний гэрлэсэн тухай үлгэрийн өгүүлэгдэхүүнийг ашиглажээ. Ашигласан байдлаас үзвэл, Бигармижид хааны тууж ба Арташид хан хөвгүүний туужийн алиныг нь ч сайн мэддэг, түүний дээр баатарлаг гэрлэлтийн сэдэвт монгол үлгэр, туулиудыг ч сайн мэддэг хүн анх зохиожээ. Анх зохиосон хувилбарын үйл явдал Бигармижид хааны гэрлэсэн тухай үйл үлгэртэй ойролцоо байжээ.

3. Боловсруулалтын онцлог ба хувьсал өөрчлөлт: Өмнө дурдсан дөрвөн хувилбараас Ховд аймгийн үлгэрч Жамъяншаравын Гонгорын хэлсэн “Амгашид хаан, Ачит хаан хоёр” үлгэр нь анхдагч хэлбэрээ хадгалсан байна. Гэвч үйл явдлын бүдүүвчийг эс тооцвол, тус үлгэрийн гол дүрүүд болох Амгашид, Ачит хаан нар нь монгол туулийн гол

баатруудтай ижил ар, өвөр нутгаараа дүүрэн ай түмэн мал сүрэг, шүтдэг тахидаг уултай, сайн хүлэг морьтой, нүүдэлчин язгууртнууд байх ба зохиолын үг хэллэг, хэл найруулга нь цэвэр монгол үлгэр, туулийн хэл найруулга байна.

Зохиолд дүрслэгдэж буй ахуй амьдрал, ёс журам бол өдөр тутмын нүүдэлчин монгол ахуй. Энэхүү монгол туулийн дүрслэлийн нэг онцлог нь зуны лүгхийм манарсан халуун өдрийг «хун төөрмөөр манантай, хулан цангамаар халуун» гэж хэлсэн байдаг. Агуулга нь:

Ачит хаан, Амгашид хаан хоёр байжээ. Нэг өдөр Амгашид дүү нь бэр эгчээсээ аяга цай халааж өгөхийг гуйхад «Би бурхны тоос арчаад завгүй байна. Аягачин хүүхнээр халаалгаж уу!» гэв. «Заавал танаар халаалгаж ууна» гэхэд, «Баруун хойд тивд гурван зандан модны орой дээр суудаг алтанхан цэцгээс гарсан Алтан дагиныг авчирч цайгаа халаалгаж уу» гэжээ. Ингээд Амгашид хаан алтан шарга морио сойж унаад явахад, бэр эгч нь замд тохиолдох саад бэрхшээлийг нь зааж өгөв. (Энэ бэргэний дүр Бигармижид хааны туужид гардаг Цэцэг хатан, түүнчлэн Арташид хааны туужид гардаг Төгсгэрэлтээс эрс ондоо монгол туульд гардаг ухаант бэргэний дүрийн хэв шинжтэй) Замдаа хорт могойн хөндийг эсэн мэнд туулж гараад, гурван ургаа зандан модонд хүрч, модыг булгална гэж сүрдүүлж байгаад Алтан дагиныг модноос буулган авч, нутагтаа харьж ирэхэд ах нь дотроо хааш хаашаа алд дэлэм хэмжээтэй алтан гүнгэрваатай өргөө гэр бэлдсэн байв. Удалгүй Амгашид хаан, Алтан дагина хоёр хүүтэй боллоо.

Нэг өдөр хаяаных нь хар халзан чөтгөр Алтан дагиныг үзэхээр ирж хаяагаар шагайв. Нэг хар халзан юм хаяагаар цухуйхаар нь Алтан дагина бариад автал, чөтгөр дүрдээ хувираад Алтан дагиныг алтан гүнгэрваанд хийж төмөр тороод торлож гадаад далайн тэг дунд шидэж орхиод, өөрөө Алтан дагинын дүрд хувилна. Амгашид хааныг ирэхэд хүүгээ алдчихлаа гээд амаараа шороо үмхэж хэвтэхэд, Амгашид хаан итгэж “Бид дахиад хүүтэй болно” гэж аргадаад хуучин янзаараа аж төрнө. Гэтэл Алтан дагина өглөө бүр эх, бэр хоёртоо цайныхаа дээжийг өгдөг байж. Үүнийг Алтан дагинын дүрд хувилсан чөтгөр мэдэхгүй тасалдуулснаас болж ухаант бэр эгч нь хар халзан чөтгөр болохыг тааж мэдээд Амгашидэд хэлэхэд, Амгашид үл тоов. Гэтэл нэг өдөр гадаад далайн тэг дунд алтан гүнгэрваа нь харагдахад очоод автал, дотроос нь Алтан дагинатай яг адилхан хүүхэн гарч ирэв. Гэртээ авч ирээд хоёр адилхан Алтан дагиныг ялгаж эс чадаад, бэр эгчээсээ асуухад, хоёулангийнх нь орой дээрх алтан цэцгийг аваад хаячих. Тэгвэл жинхэнэ Алтан дагинын толгой дээр

мөнгөн бурхан хүрээлэнхэн тоглож байгаа. Хар халзан чөтгөр бол орой дээр нь мөнгөн чөтгөр хямралдаж байгаа гэжээ. Ууртай давхиж ирээд хоёулангийнх нь алтан цэцэгсийг аваад шидчихсэнд, бэр эгчийнх нь хэлсэн ёсоор болж, Хар халзан чөтгөрийг таньж дарж аваад, амар сайхан жаргана.

Энд гарч буй Хар халзан чөтгөрийн дүр бол Бигармижид хааны туужид гардаг Махасамади хааны хоньчин Раднагийн эхнэр Их хар нэрт болно. Их хар нөхөртэйгээ хэрэлдэж, далайд унаж үхнэ гэж гүйж явахдаа Цэцэг хатны өвдгийг дэрлэн унтсан Бигармижидийг олж үзэв. Хатан айж сандран цэцэг дотор орж нуугдахад, Их хар тэр цэцгийн амсрыг боож далайд шидээд, Бигармижидийг мэхэлж хатан нь болдог. Энэ Их хар гэгч Цэцэг хатны дүрд хувилдаггүй. Харин Гонгорын хэлсэн монгол үлгэрт Хар халзан чөтгөр Алтан дагинын дүрд ялгах аргагүй адилхан болж хувилдаг. Цэцэг хатныг далайд шидсэнээс хойш олон үйл явдал өрнөдөг боловч тэдгээрийг монгол үлгэрт хуулж давтсангүй, гагцхүү цэцэн ухаант зөвлөх дүр болох бэр эгчийн тусламжтайгаар учир явдлын зангилаа тайлагдаж буй хялбар бөгөөд сонирхолтой үйл явдалтай болгожээ. Бигармижид хааны тууж дахь Цэцэг хатны гэр болох алтан цэцгийн оронд монгол үлгэрт хааш хаашаа алд дэлэм хэмжээтэй алтан гүнгэрвааг зохиож бий болгожээ.

Баатарлаг гэрлэлтийн сэдэвт монгол туульд баатар эр сүйт бүсгүйгээ зорьж явах замдаа бух, чоно, буур, азарга зэрэг замд тохиолдсон бүхнийг барьж хөнөөдөг зэрлэг адгуустай тааралдаж, тэдгээрийг хөнөөж цааш явах сорилттой тулгардаг. Түүний оронд Арташид хан хөвгүүний туужаас сэдэвлэсэн монгол туульд баатар эр хорт могойн хөндийг мориныхоо хүчээр арай гэж туулдаг (Гонгорын..., 2008:174., Тогтох, Ласугмаа, 1995: 292-295). Ийнхүү үлгэрч Гонгорын хэлсэн «Амгашид хаан, Ачит хаан» гэдэг үлгэр бол Арташид хан хөвгүүний тууж дахь Амока хан хөвгүүний хатангүй үлдсэн тухай мотивоос сэдэвлэгдэж, Цэцэг хатныг Бигармижид хаан залсан тухай үлгэрийн үйл явдлыг ашиглан боловсруулж зохиосон баатарлаг гэрлэлтийн сэдэвт монгол үлгэр мөн. Энэтхэг, Төвөдийн хоёр өөр зохиолын үйл явдлыг холбож, дундаас нь монгол үлгэр шинээр зохиосон энэхүү уран сайхны арга бол монгол утга зохиолын түүхэнд тэмдэглэгдэх өвөрмөц үзэгдэл гэж үзэж байна.

Арташид хан хөвгүүний туужаас сэдэвлэсэн үлгэр, туулийн хувилбаруудыг харьцуулж амаар уламжлан тархахдаа хэрхэн өөрчлөгдөж хувирсныг үзвэл, Бигармижид хааны туужийн үйл явдалтай нэлээд ойр

дөхөм байгаагаараа Гонгорын хэлсэн үлгэр нь анхдагч эхийн шинжтэй байна. Энэ эх (текст)-ийн хэл найруулга үлгэрийн төрөлд хамаарна.

Дараагийн текст болох академич Б. Ринчен 1928 оны гуравдугаар сард бичиж авсан "Ар замбуулин" нэртэй тууль нь цэвэр халх туулийн хэл найруулгатай бөгөөд Амгашид хаан бэрх замыг туулан явж Алтан дагинад хүрч очсоноос хойших үйл явдал дутуу (Халх тууль, 2013: 72-78) байх учраас гарал уламжлалын талаар тодорхой зүйл хэлэхэд бэрхшээлтэй.

Шинэ барга зүүн хошууны Шинэбулаг сумын иргэн Даваа хэлсэн "Арташид хан, Амагашид" гэдэг тууль, Пунцагнамжилын эмхэтгэсэн "Сэцэлэй мэргэн хаан" (барга ардын үлгэр) номд нийтлэгдсэн "Амгаа сайт хаан, Артаа сайт хаан" үлгэр нь үйл явдлаараа хоорондоо адил ажээ. Барга хувилбаруудад Амагашид хан бэр эгчийнхээ зөвлөснөөр тэнгэр, газрын захад байдаг арван салаат модноос мэндэлсэн Алтанцэцэг дагиныг авч ирээд амар сайхан жаргаж буй үйл явдал гарах ба Гонгорын хэлсэн хувилбарт гарч буй хар халзан чөтгөртэй холбогдох үйл явдлууд байдаггүй. Үүнээс үзэхэд уг монгол тууль нь анх Монгол Улсын баруун халхуудын дунд зохиогдож, өрнө зүг тархахдаа баргуудын дунд Алтан дагиныг Амгашид хаан авчирснаар төгсөж буй үйл явдлын хүрээнд уламжлагдсан байна.

ДҮГНЭЛТ

1. Монголчууд Арташид хан хөвгүүний туужаас сэдэвлэж Амока хан хөвгүүний гэрлэсэн тухай үлгэрийг амаар зохиохдоо Бигармижид хан хөвгүүний гэрлэсэн тухай үлгэрийн өгүүлэгдэхүүнийг уламжлалт баатарлаг гэрлэлтийн сэдэвт монгол туулийн загварт оруулан зохиожээ. Үлгэрийг анх зохиогч нь Бигармижид хааны тууж ба Арташид хан хөвгүүний туужийн алиныг нь ч сайн мэддэг, түүний дээр баатарлаг гэрлэлтийн сэдэвт монгол үлгэр, туулиудыг ч сайн мэддэг хүн байжээ. Анх зохиосон хувилбарын үйл явдал Бигармижид хааны гэрлэсэн тухай үйл үлгэртэй ойролцоо байжээ.
2. Арташид хаан хөвгүүний туужаас сэдэвлэсэн үлгэрүүдээс Ховд аймгийн Буянт сумын харьяат үлгэрч Гонгорын хэлсэн "Амгашид хаан, Ачит хаан" гэдэг үлгэр нь анхдагч эхийн шинжтэй, дэлгэрэнгүй хувилбар байна. Тус үлгэр зүүн тийш ам дамжин түгэхдээ үйл явдал нь товчлогджээ.
3. Энэтхэг, Төвөдийн хоёр өөр зохиолын үйл явдлыг холбож, дундаас нь монгол үлгэр шинээр зохиосон энэхүү уран сайхны арга бол монгол утга зохиолын түүхэнд тэмдэглэгдэх өвөрмөц үзэгдэл мөн.

НОМ ЗҮЙ

Гонгорын 2008: Гонгорын хэлсэн үлгэр, туульс. Монгол аман зохиолын чуулган. XXXIV. (Ред: П. Хорлоо). УБ.: “Орчлон принт” ХХК, 2008.

МУЗТ. II.1977: *Монголын уран зохиолын тойм.* II.XVII-XVIII зууны үе. (Ред: Ц. Дамдинсүрэн, Д. Цэнд). УБ.,1977.

Сэцэнбат 2020: *Сэцэнбат Ц.* Бурхны шашны судрын үлгэрийн монгол аман уламжлалын судлал. (Ред: Б. Мөнхбаяр). УБ.: “Бемби сан” ХХК, 2020.

Тогтох Т, Ласугмаа 1995: Бужгар буурал морьтой Бужалдай хан. (Т. Тогтох, Ласугмаа эмхэтгэв). Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 1995, монгол бичгээр.

Халх тууль 2013: ССАЖЯ, СӨТ. ЮНЕСКО-ийн МҮК. (Хэвл. бэлтгэн, удиртгал бичсэн А. Алимаа; Ред: Б. Катуу). УБ.: “Соёмбо принтинг” ХХК, 2013.

Sayinuqaɤantu. *Sayinuqaɤantu blam-a Artasidi nom-un qaɤan qoyar-un onol-iöɤülegsen čedig niɤučayin esi kemekü orosiba.* Бээжин барын судар. 66 хуудас. 10 х 47.5 см. 26 мөр, хятад цаас// ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн хөмрөг. 824.